

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/011/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитор: Ж.Баясгалан Утас: 7036-3047 Цахим хаяг: bayasgalanj@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ТҮШИГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.БАРАМСАЙ ТАНАА

2026.03.25 № 10А-2026/011/УА-СА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20.2.5 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 3.3, Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 2 дугаар зүйлийн 2.5, 2.5.3, 7 дугаар зүйлийн 7.4, 7.4.1, 11 дүгээр зүйлийн 11.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2, Сангийн сайдын, 2021 оны 190 дүгээр тушаалын холбогдох заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн

2

4326050362

тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 107,142.3 мянган төгрөгөөр тасалсан,
- ХХС-ийн 2025 онд олгосон 35,000.0 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөх хуваарьт үндсэн төлбөрийг чөлөөлөх хугацааг журамд заасныг зөрчин 55 сараар чөлөөлөхөөр тусгасан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй,
- Илүү цагийн нэмэгдэл хөлсийг журамд заасан хэмжээнээс хэтрүүлэн нийт 7,992.5 мянган төгрөгийг тооцож олгосон,
- Хөдөлмөр аюулгүй байдлын ажлыг мэргэжлийн бус албан хаагчаар хавсран гүйцэтгүүлж 4,075.1 мянган төгрөгийн цалин олгосон,
- Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал, бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй 2,732.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын ИТХ-ын “Түшиг сумын “2025 оны тодотгосон төсөв батлах тухай” 37 дугаар тогтоолоор тайлант онд 909,227.8 мянган төгрөгийн татварын орлого, 21,700.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт 930,927.8 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 823,785.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 11.5 хувиар тасалсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант жилд Түшиг суманд хуурайшилт ихтэйгээс ой хээрийн түймэр их гарч иргэд, байгууллага, албан хаагчид түймэр унтраахад ажилласан бөгөөд үүнтэй холбоотой аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс түймэрт ажилласан албан хаагчдын хоол хүнс, шатахуунд зориулж 41,653.3 мянган төгрөгийг олгосон байна

Бусад асуудлын хэсэг

Түшиг сумын Засаг дарга нь тайлант онд 6 зорилт, 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 80.9 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,507,954.19	1,757,562.30
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,098,358.77	883,020.54
3	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	323,575.77	140,067.58
4	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	86,019.64	734,474.18
5	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,465,423.61	3,320,119.12
6	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,465,423.61	3,320,119.12
7	Биет хөрөнгө		2,396,646.56	3,249,782.07
8	Биет бус хөрөнгө	13	68,777.05	70,337.05
9	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		3,973,377.80	5,077,681.42
10	НИЙТ ӨР ТӨЛБӨР		34,952.77	45,352.47
11	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		34,952.77	45,352.47
12	Өглөг		34,952.77	45,352.47
13	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,938,425.04	5,032,328.94
14	Засгийн газрын хувь оролцоо		3,938,425.04	5,032,328.94
15	Засгийн газрын оруулсан капитал		351,845.22	351,845.22
16	Хуримтлагдсан үр дүн		3,356,573.08	4,450,476.99
17	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		230,006.73	230,006.73
18	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		3,973,377.80	5,077,681.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		3,207,562.63	3,709,056.67
2	ТАТВАРЫН ОРЛОГО		721,305.18	788,378.84
3	Орлогын албан татвар		378,100.83	377,005.52
4	Хувь хүний орлогын албан татвар		413,003.05	415,215.39
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-34,902.22	-38,209.87
6	Хөрөнгийн албан татвар		43,783.26	92,694.33
7	Бусад татвар, төлбөр, хураамж		299,421.09	318,679
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	645,063.54	2,920,677.83
9	Тусламжийн орлого		0.00	1,255,479.12
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,841,193.90	0.00
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,692,541.09	2,053,449.91
12	УРСГАЛ ЗАРДАЛ		1,692,541.09	1,916,809.22
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,649,064.49	1,862,177.68
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		715,022.06	974,924.36
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		88,363.58	125,514.86
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		344,798.08	381,664.55
17	Хангамж, бараа материалын зардал		70,011.63	76,844.39
18	Нормативт зардал		0.00	14,292.05
19	Эд хогшил, урсгал засварын зардал		129,737.73	42,109.46
20	Томилголт, зочны зардал		19,407.00	8,551.00

21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		23,577.07	39,285.86
22	Бараа үйлчилгээний бусад зардал		258,147.33	198,991.14
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		43,476.60	54,631.54
24	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.00	136,640.69
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,515,021.54	1,655,606.76
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		520,269.56	561,729.35
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-520,269.56	-561,729.35
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		994,751.98	1,093,877.41

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,943,673.06		2,943,673.06
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,943,673.06		2,943,673.06
3	Тайлант үеийн үр дүн	994,751.98		994,751.98
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,938,425.04		3,938,425.04
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,938,425.04		3,938,425.04
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	26.50		26.50
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,938,451.54		3,938,451.54
8	Тайлант үеийн үр дүн	1,093,877.41		1,093,877.41
9	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,032,328.94		5,032,328.94

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,643,949.58	3,012,904.32
2	ТАТВАРЫН ОРЛОГО	721,305.18	788,378.84
3	Орлогын албан татвар	378,100.83	377,005.52
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-34,902.22	-38,209.87
5	Хөрөнгийн албан татвар	43,783.26	92,694.33
6	Бусад татвар, төлбөр, хураамж	299,421.09	318,679
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	65,911.49	9,720.95
8	Газрын төлбөр	61,398.45	40,735.56
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	172,111.15	268,222.49
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,450.49	2,224,525.48
11	Нийтлэг татварын бус орлого	81,450.49	89,723.86
12	Тусламжийн орлого	0.00	1,255,479.12
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	879,322.50
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,841,193.90	0.00
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,526,465.89	1,896,544.7
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,526,465.89	1,896,544.7

17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,482,989.28	1,841,913.16
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	716,492.06	974,924.36
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,884.56	125,514.86
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	344,798.08	381,664.55
21	Хангамж, бараа материалын зардал	70,676.64	68,196.12
22	Нормативт зардал	0.00	14,292.05
23	Эд хогшил, урсгал засварын зардал	130,406.48	46,964.46
24	Томилолт, зочны зардал	19,407.00	8,551.00
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,715.87	147,085.86
26	Бараа үйлчилгээний бусад зардал	96,608.60	74,719.90
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,476.60	54,631.54
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,117,483.69	1,116,359.62
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,128,735.23	1,296,697.85
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,128,735.23	1,296,697.85
31	Дотоод эх үүсвэрээр	1,128,735.23	1,296,697.85
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,128,735.23	-1,296,697.85
33	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	35,000.00
34	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	-35,000.00
35	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-11,251.54	-215,338.23
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,109,610.31	1,078,342.0
37	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,078,342.0	837,795.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,072,547.5	3,175,878.4	896,669.1	78.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,263,613.6	1,844,180.6	419,433.0	81.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,196,131.4	1,789,549.0	406,582.4	81.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,053,760.1	974,541.9	79,218.2	92.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,477.5	125,514.9	12,962.6	90.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	433,781.3	381,664.6	52,116.7	88.0
2104	Хангамж, бараа материалын зардал	44,109.0	37,511.8	6,597.2	85.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,812.6	46,489.5	3,323.1	93.3
2107	Томилолт, зочны зардал	12,093.5	8,551.0	3,542.5	70.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	384,779.1	142,555.6	242,223.5	37.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,318.3	72,719.9	6,598.4	91.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,482.2	54,631.5	12,850.7	81.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,482.2	54,631.5	12,850.7	81.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,693,745.7	1,296,697.9	397,047.8	76.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН	115,188.2	35,000.0	80,188.2	30.4

ЦЭВЭР ЗЭЭЛ					
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,712,152.4	(146,472.3)	1,858,624.7	
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(1,712,152.4)	146,472.3	(1,858,624.7)	
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(1,712,152.4)	146,472.3	(1,858,624.7)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,078,342.0	(1,078,342.0)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	837,795.2	(837,795.2)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	50	50	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	26	26	-	100.0
620001	Удирдах ажилтан	4	4	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	6	6	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26	26	-	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	-	100.0
650010	Гэрээт ажилтан	5	5	-	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/мянган төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	47,833,816.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,833,816.00	
122	Тусламжийн орлого	47,833,816.00	
1221	Хандив тусламж /дотоод/	47,833,816.00	
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,833,816.00	
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,239,589.00	
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,562,967.00	
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,031,260.00	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,833,816.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,833,816.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,833,816.00	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,445.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	30,684,317.00	
2105	Нормативт зардал	14,292,054.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	475,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түшиг сумын ТТЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баясгалан гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Отгонбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх нар тус тус хэрэгжүүлсэн.

Түшиг сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/65 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 1,692,541.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 16,925.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Түшиг сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Албан хэрэг хөтлөлтийг цахимжуулж бичиг хэргийн зардлыг бууруулсан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй
- Бичиг хэргийн зардлыг хэмнэх зорилгоор албан бичгийн төрийн байгууллага хооронд тогтмол ERP системээр дамжуулан ажиллаж байгаа,
- Сумын төсвийн байгууллага дээр бүртгэлтэй бүх тээврийн хэрэгслийг цэнхэр дэвсгэртэй дугаартай болгосон гэх мэт...

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 11. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Хугацаанд мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	181	181	-	-
2	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	183	180	2	1
3	Сумын Засаг даргын Тамгын газар	183	179	3	1
	Нийт дүн	547	540	5	2

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

1. Тайлант хугацаанд Түшиг сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих нийт 547 мэдээллээс 540 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж үзлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 433 дугаар “Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 81,580.8 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага өгснийг нотлох баримттай тулган баталгаажуулахад бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	3	81,580.8	3	81,580.8	100.0
Зөвлөмж	-	-	-	-	-
Нийт дүн	3	81,580.8	3	81,580.8	100.0

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **315,254.3** мянган төгрөгийн зөрчил илэрч, 7,992.5 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 148,949.4 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 158,312.4 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 315,254.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 298,328.9 мянган төгрөгөөр их тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө

5.1 Төлбөрийн акт:

Илүү цагийн нэмэгдэл хөлсийг журамд заасан хэмжээнээс хэтрүүлэн ЗДТГ нь 12 албан хаагчид 5,501.1 мянган төгрөгийн , ИТХ нь 3 албан хаагчид 2,491.4 мянган төгрөгийн зэрэг нийт 7,992.5 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 3.3 “Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь, 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 107,142.3 мянган төгрөгөөр тасалсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлогын төвлөрүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээ авч, орлогыг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

2. ЗДТГ нь нийт 2,732.0 мянган төгрөгийг зориулалт бусаар буюу зардлын эдийн засгийн ангилал, арга хэмжээ хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” -ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай тохиолдолд төсвийн зохицуулалт хийж байх албан шаардлага хүргүүлэв.

3. ХХС-ийн 2025 онд 1 хоршоонд олгосон 35,000.0 мянган төгрөгийн зээлийг гэрээнд эргэн төлөх хуваарьт үндсэн төлбөрийг чөлөөлөх хугацааг журамд заасныг зөрчин 55 сараар чөлөөлөхөөр тусгасан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 2 дугаар зүйлийн 2.5 “*Сангаас хоршоонд олгох хөнгөлөлттэй зээл нь дараах нөхцөлтэй байна*”, 2.5.3 “*зээлийн эргэн төлөлтийн эхний 12 хүртэлх сарын хугацаанд үндсэн төлбөрөөс чөлөөлж болно*”, 7 дугаар зүйлийн 7.4 “*Хяналтын зөвлөл сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавихдаа дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ*”, 7.4.1-т “*зээл авсан хоршооны үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн тайлан, дансны мэдээллийг гаргуулан авах*”, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “*Сангаас зээл авсан этгээд зээлийг үр ашиггүй зарцуулсан буюу зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн болон барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн этгээдэд олгосон хөнгөлөлттэй зээлийг буцаан төвлөрүүлэх бөгөөд сангаас дахин зээл олгохгүй*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ХХС-аас зээл олгохдоо эргэн төлөх хуваарийг журамд заасан нөхцөлийг баримталж, хэрэгжилтэд хяналт тавьж байх албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант онд хөдөлмөр аюулгүй байдлын ажлыг мэргэжлийн бус албан хаагч буюу ЗДТГ-ын дарга Б.Уранчимэгээр 1-10 сард хавсран гүйцэтгүүлж 4,075.1 мянган төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх “*Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнаар инженер, техникийн болон эрүүл ахуйн боловсролтой, мэргэшсэн хүнийг ажиллуулна*” -ыг гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ХАБ-ын албан үүргийг мэргэшсэн сургалтад хамрагдсан албан хаагчаар хавсран гүйцэтгүүлэх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт: ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 16 нэр төрлийн хөрөнгийг актлах болон цаашид ашиглах эсэх саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 “ ... элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн ХЗУ¹4-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй ...” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.1.1 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

2. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлтэй холбоотой:

2.1. Илрүүлэлт: ХХС-ийн чанаргүй зээлийн хэмжээ нийт зээлийн 76,415.9 мянган төгрөг буюу 68.6 хувийг эзэлж байгаа атал зээл төлүүлэх үр дүнтэй арга хэмжээ аваагүй, хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 7.1 дэх Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнг дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр үнэлнэ: 2 “Чанаргүй зээлийн хэмжээ-Нийт хөрөнгийн 10 хувиас бага байх”, 10.5 дахь “Зээлдэгчийн гэрээнд эрсдэл үүссэн тохиолдолд зээлийн хөрөнгийг эргүүлэн татах ажиллагааг сумын Засаг дарга болон хяналтын зөвлөл хариуцан зохион байгуулна. Энэхүү зохицуулалтыг зээлийн гэрээгээр нарийвчлан зохицуулна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд “УСНББОУС-2: Мөнгөн хөрөнгө”

¹ ХЗУ-Хэрэгжүүлэх заавар удирдамж

санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

2.1.1 Өгсөн зөвлөмж: Чанаргүй зээлийн үлдэгдлийг бууруулах шат дараалсан арга хэмжээг авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 09 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	3	218,558.20			2	142,142.30	1	76,415.9				
ИТХ	1	2,491.40	1	2,491.40								
ЗДТГ	4	94,204.90	1	5,501.30	2	6,807.10	1	81,896.5				
Дүн	8	315,254.50	2	7,992.70	4	148,949.40	2	158,312.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ИТХ нь шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээллийг хугацаа хоцроож 1 мэдээллийг огт мэдээлээгүй байна.	1						1	
ЗДТГ нь шилэн дансны цахим хуудсанд 3 мэдээллийг хугацаа хоцроож 1 мэдээллийг огт мэдээлээгүй байна.	1						1	
Дүн	2						2	
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчил								
Дүн								
Нийт дүн	2						2	